



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 21 өдөр

Дугаар A/476

Улаанбаатар хот

Үлгэрчилсэн дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан үлгэрчилсэн дүрмийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дүрмээ боловсруулж, батлан хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2011 оны
11... дугаар сарын 24... өдрийн
А/1446 дугаар тушаалын хавсралт

**Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,
нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм**

Нэг. Нийтлэг зүйл

Энэхүү дүрэм нь Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа, дарга гишүүдийн чиг үүрэг, эрх зүйн байдлын дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд удирдамж болно.

Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг

2.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17.10-д заасан эрхийг эдэлж, тус хуулийн 17.11-д заасан үүргийг хэрэгжүүлэн ажиллана.

Гурав. Төлөөлөн удирдах зөвлөлийн баримтлах зарчим

3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 3.1.1. Хууль дээдлэх зарчмыг мөрдлөг болгох;
- 3.1.2. Үйлчлүүлэгч, олон нийт, байгууллагын эрх ашгийг дээдлэх;
- 3.1.3. Асуудлыг ил тод нээлттэй, гишүүдийн оролцоог бүрэн хангасан байдлаар шийдвэрлэх;
- 3.1.4. Ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх.

Дөрөв. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан

4.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны хуралдааныг дараахь байдлаар зохион байгуулна.

4.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны хуралдааныг ЭМЯ болон аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газрын дэргэд байгуулсан Сонгон шалгаруулах ажлын хэсгээс зохион байгуулна.

4.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны хуралдаанаар Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15.6-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгоно.

4.1.3. Сонгон шалгаруулах ажлын хэсгийн үйл ажиллагаа энэхүү дүрмийн 4.1.1, 4.1.2 –т заасан үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлснээр дуусгавар болно.

4.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15.15-д зааснаар улиралд нэгээс доошгүй удаа хуралдсан байна.

4.2.1. Хуралдааны зард хуралдааны зорилго, зохион байгуулах өдөр, цаг, болох газар, хэлэлцэх асуудлыг тусгасан байна. Хуралдааны зар болон хэлэлцэх асуудлын материалыг хуралдаан болох өдрөөс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

4.2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга тухайн жилийн хуралдааны төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сард багтаан батална.

4.2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдааны шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар эцэслэн шийдвэрлэнэ.

4.2.4. Саналыг ил, тод нээлттэй байдлаар авах ба шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдтэй зөвшилцсөнөөр “нууцаар” авч болно.

4.2.5. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.

4.2.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын зөвшөөрснөөр хуралд “зайнаас” (теле конференц хэлбэрээр) оролцож болох ба энэ тохиолдолд тухайн гишүүн хуралд “бүрэн эрхтэйгээр оролцсон” гэж үзнэ.

4.2.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцолгүйгээр урьдчилсан санал өгсөн тохиолдолд тухайн саналыг санал өгсөнд тооцон шийдвэр гаргана.

4.2.8. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15.15-д зааснаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно. Төлөвлөгөөт бус хуралдааныг “ээлжит бус хуралдаан” гэнэ.

4.2.9. Ээлжит болон ээлжит бус хуралдааны алинд ч хурал зохион байгуулах хүчинтэй ирцийн хувь 75 хувиас доошгүй байна.

4.2.10. Ээлжит бус хуралдааныг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, эсхүл эмнэлгийн захирал санаачилж, таваас доошгүй гишүүн дэмжсэн тохиолдолд хуралдуулна.

4.2.11. Ээлжит бус хуралдааны зарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга ажлын 7 хоногийн дотор түгээж, хуралдааныг зохион байгуулна.

4.2.12. Хуралдааныг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын шийдвэрээр дараах тохиолдолд хуралдах хугацааг түр хойшлуулж, дараагийн 14 хоногт багтаан хуралдуулна.
. Үүнд:

4.2.12.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд хуралдаантай холбогдох материалыг энэ журмын 4.2.1-д заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд;

4.2.12.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ирц энэхүү журмын 4.2.9-т заасан 75-аас доошгүй хувь бүрдээгүй тохиолдолд.

4.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаас Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15.18-д заасны дагуу тогтоол, шийдвэр гарах бөгөөд хэрэгжилтэд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хяналт тавин ажиллана.

4.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын түр эзгүйд Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15.9-д зааснаар түүний санал болгосон гишүүн, хэрэв санал болгоогүй тохиолдолд насаар хамгийн ахмад гишүүн орлоно.

4.5. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15.20-д зааснаар Төлөөлөн удирдах зөвлөл нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор гишүүдийн олонхийн саналаар томилно.

4.6. Шаардлагатай асуудлаар санал, дүгнэлт гаргуулах, хяналт тавих, үнэлгээ хийлгэх, зөвлөмж гаргах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөл ажлын хэсэг байгуулах, бие даасан шинжээч томилон гэрээгээр ажиллуулж болно.

4.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15.11-д заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Тав. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15.14-д заасан үүрэг хүлээнэ.

5.1. Төлөөлөн удирдах зөвлөл болон эмнэлгийн гүйцэтгэх удирдлагын хооронд үр дүнтэй, ил тод харилцааг бий болгох;

5.2. Эмнэлгийн захирлын ажлын гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг нэгтгэн дүгнэх;

5.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлын бэлтгэл ажлыг хянах, хурлыг даргалах;

5.4. Ашиг сонирхолын зөрчил, мэдээллийн нууцлал болон зарчмын илт зөрүүтэй асуудлыг таслан зогсоох, арга хэмжээ авах;

5.5. Эмнэлгийн захиралтай болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдтэй зөвлөлдөж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудлыг тодорхойлох;

5.6. Олон нийтэд болон албан ёсны арга хэмжээнд Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлөх;

5.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа салбарын бодлого болон эмнэлэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн бодлого, зорилготой нийцэж буй эсэхэд хяналт тавих;

5.8. Төлөөлөн удирдах зөвлөл өөрийн эрх, үүргийн хүрээнд бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

5.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр ханган ажлын гүйцэтгэлийг хянаж үнэлэх.

Зургаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг

6.1. Нарийн бичгийн дарга нь Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15.18-д зааснаар хуралдаанаар хэлэлцсэн, санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал, санал хураалтын дүн, гаргасан шийдвэрийн тэмдэглэлийг тухай бүр хөтөлж, шийдвэрлэсэн асуудлаар тогтоолын төсөл боловсруулах бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар тогтоолд гарын үсэг зуруулж, баталгаажуулах;

6.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг гишүүдэд цаг хугацаанд нь хүргүүлэх;

6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн хөтлөх, архив үүсгэх;

6.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд хурлын зар болон хурлаар хэлэлцүүлэх материалыг бүрдүүлэх, хувилах, зөвлөлийн нийт гишүүдэд цаасаар эсвэл цахим хэлбэрээр түгээх, шаардлагатай мэдээллээр хангах;

6.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан, ажлын хэсгийн хурал, уулзалтыг зохион байгуулах;

6.6. Төлөөлөн удирдах зөвлөл холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын, сургалтын, хувийн хэвшлийн болон бусад байгууллагатай харилцах харилцааг зохицуулах.

6.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгох урамшуулал, удирдах зөвлөлтэй холбоотой зардлыг төсөвлөн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах;

6.8. Эмнэлгийн захирлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээ, мэдээллийг тодорхой давтамжтай цуглуулж, дүн шинжилгээ хийх.

Долоо. Хариуцлага хүлээх

7.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хууль зөрчсөн тохиолдолд Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авилгын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.